

МОНГОЛЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН ХОЛБОО

**ХҮРЭЛТОГООТ-2012
ХӨДӨӨ АЖ АХУЙ –
БИОТЕХНОЛОГИЙН
САЛБАР**

ЭМХЭТГЭЛҮҮДИЙН
ХУРААНГУЙ
SUMMARY

- Говийн аймгуудад тохиолддог онош нь тодорхойгүй Адууны өвчний судалгаанд

Б.Энхтайван, Г.Жавхлан, Б.Баттөр, Б.Батцэцэг
Мал эмнэлгийн хүрээлэн, Молекул генетикийн лаборатори
bata07@gmail.com

- Үхрийн цусан халдварыг оношлох шууд иммуно флуоресцент урвалын флуоресцент ийлдэс\lgG\ бэлтгэн сорьсон дүн

Б.Энхтуул¹, Ц.Лундаа¹,
Б.Нарангэрэл¹, Д.Ганболд²,
Б.Мөнгөн-Очир², Ж.Эрдэнэбаатар¹
¹Мал эмнэлгийн хүрээлэн,
Халдварт өвчин, дархлаа судлалын лаборатори,
²Эмгэг судлалын лаборатори

- Давсанд тэсвэрийг кодлогч *wrku1* генийг ялгаж авах ба шилжүүлэн суулгах

Б.Одгэрэл¹, Dae Yeon Kim²,
Woong Baе Jeon², Энхчимэг Ванжилдорж³, Yong Weon Seo^{*}
Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн,
2-Корей их сургууль, Биотехнологийн коллеж, Сөүл, 136-713, БНСУ
3-ХААИС, Биологийн нөөцийн менежментийн сургууль, Биотехнологи
үржүүлгийн тэнхим,
odgerel1017@yahoo.com,

- Пивоны диацетилийн хэмжээнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох судалгааны үр дүнгээс

Б.Шинэзаяа¹, С.Дэлгэрмаа (Ph.D)²
¹ ШУТИС, ХИБС, Хүнсний микробиологи, магистрант
² ШУТИС, ХИБС, Биотехнологийн баг, дэд профессор
zaya_1619@yahoo.com

- Хүний биед агаарын температурын үзүүлэх нөлөөллийг судалсан дүнгээс (Улаанбаатар хотын жишээн дээр)

Б.Шүрэнцэцэг¹, Ш.Оюунтуяа²
Монгол улс, ХААИС, Экологи, технологи хөгжлийн сургууль
¹-shuree_7111@yahoo.com
²-oyuntuya-sh@msua.edu.mn

- Говийн бүсийн лавар навчит улиасыг (*populus laurifolia* l.) Эрлийзжүүлсэн судалгааны дүнгээс

Э.Батдорж*, Б.Цэнгэл**, Х.Билгүүн***
*ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн
**МУИС Биологи-Биотехнологийн сургууль
***Tree Global Mongolia ХХК
E_hoomboo@yahoo.com

- **Leonticeae** трибийн (*berberidaceae juss.*) Үрийн хэлбэрзүй, үрийн бүрхүүлийн дотоод бүтэц

Г. Биндэръяа

Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургуулийн
Байгалийн ухааны сургууль,
Биологийн тэнхим
e-mail: binderiya_gonchigdorj@yahoo.com

- Нүцгэн ортуузын хордлогыг оношлож, хэт дархлаат ийлдэс туршсан дүн

**Д.Баярмөнх¹, Г.Оюунцэцэг¹, А. Шимада²,
В.Батбаатар¹, Ж.Эрдэнэбаатар¹**

¹Мал Эмнэлгийн Хүрээлэн,

²Тоторрогийн Их Сургууль,

Bayarmunkhd@gmail.com

- “Мах, махан бүтээгдэхүүний усны идэвхийн судалгаа ”

Д.Болорцэцэг¹, С. Лхагвасүрэн,¹ Ч.Нямцэнгэл², Ү.Нямбат³

¹ ХААИС, Мал эмнэлгийн хүрээлэн

²Экологи Технологи Хөгжлийн Сургууль

³Эдийн засаг бизнесийн сургууль

Емайл: tsasanbolor_88@yahoo.com

- Байгаль гүүн хөхийг *in vitro* нөхцөлд өсгөвөрлөх боломж

Д.Бямбасүх¹

ШУА, Ботаникийн хүрээлэн,

Ургамлын бичил үржүүлгийн лаборатори

byambasukh@yahoo.com

- Усалгаатай нөхцөлд арвайн сортуудын хуурай биомассын хуримтлалд бордооны нөлөө

Д.Хишигжаргал/ магистр¹

Д.Туул /Ph.D/

ДАРХАН-УУЛ АЙМАГ УГТЭШХ

jargald_0110@yahoo.com

- Төв аймгийн адууны хачгийн халуун өвчний Хөдлөлзүйг судалсан нь: 2007-2010 он

Г.Жавхлан¹, Б.Батцэцэг¹

¹Мал Эмнэлгийн Хүрээлэнгийн Молекул Генетикийн Лаборатори,

Монгол улс, Улаанбаатар хот 210153, Зайсан

javkhlan.g@gmail.com

- Дорнод аймгийн хур тунадасны өөрчлөлт

Г. Мэндсайхан¹, Н.Цэрэнсодном²

¹ Монгол улс, ХААИС, Экологи, технологи хөгжлийн сургууль

¹- mendee_cool@yahoo.com

²- tseke_baby88@yahoo.com

- Эрчимжсэн сүүний үхрийн фермерийн аж ахуйн газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд тулгамдаж буй асуудал

И.Ганчимэг¹, Ph.D Ч. Баасанжаргал¹, Ph.D А.Бааст²

Монголын Үндэсний Их Сургууль,

Газар зохион байгуулалтын удирдлагын тэнхим

E mail: Ganaa_882888@yahoo.com

- Шаргал лидрийн (*sophora flavescens soland*) *in vitro* үржүүлэгт өсөлтийн бодисуудын нөлөө

М. Цолмон

ШУА, Ботаникийн хүрээлэн,

Ургамлын бичил үржүүлгийн лаборатори

И-мэйл: Tsolmonbot@gmail.com,

- Царгас (*medicago varia marthz.cv*) –ны *in vitro* үржүүлэг болон абиотик стресст тэсвэржүүлэх генийн трансформацийн системийн тохируулга

М.Ууганзаяа¹, Tae Wan, Kim², Tae-Seok, Ko²

m.uuganzaya@yahoo.com

¹ Тэжээлийн ургамлын эдийн өсгөврийн лаборатори

Бэлчээр тэжээлийн салбар, МAAЭШХүрээлэн

² Эмийн ургамлын тэнхим, Хангён Үндэсний Их Сургууль,

- Ашигт бичил биетэн ашиглан байгаль орчины бохирдол бууруулах боломжийн судалгаа

М.Мэнд-Амар, Б.Оюунбилэг, Б.Пагмадулам, Д.Цэрэндулам

Биологийн хүрээлэн, Микробын нийлэгжлийн лаборатори

mendamar@rocketmail.com

- Гүүнний вирус-(герпес i)-г хээл хаях өвчний үүсгэгчийг таньцалсан дүнгээс

Н.Даваасүрэн¹, Ч.Тунгалаг¹, Б.Пүрэвцэрэн²

¹Мал Эмнэлэг Биотехнологийн Сургууль,

Халдварт, паразитгах өвчин судлал микробиологийн тэнхим

²Мал эмнэлгийн хүрээлэн, Вирус судлалын лаборатори

E .mail: dabaa_vet@yahoo.com

- Ботаникий цэцэрлэгт тарималжуулж буй зарим эмийн ашигт ургамлын усан солилцооны онцлог

Н.Хандмаа¹

¹ШУА-ийн Ботаникийн хүрээлэн

n_khandaa_1122@yahoo.com

- Японы энцефалит өвчнийг шууд бус ФХЭБУ, ПГУ-аар оношлосон дүн
Н.Оюунномин¹, Б.Болдбаатар²
¹Мал Эмнэлэг Биотехнологийн Сургууль,
Халдварт, паразиттахөвчинсудлал, Микробиологийн тэнхим
²Мал Эмнэлгийн Хүрээлэн, Вирус судлалын лаборатори
E.mail: egshig_1214@yahoo.com
- Мэс заслын аргаар туршуул хээлтүүлэгч бэлтгэж, Зохиомол хээлтүүлэг хийсэн
үр дүнгээс
Ө.Нурбол¹ магистрант, С.Бямбацогт¹ Доктор Ph.D,
1.ХААИС, Мал эмнэлэг, биотехнологийн сургууль
Nurbol_o@yahoo.com
- Эмийн бамбай (*valeriana officinalis* L.)-н бичил ургамлыг *in vitro*-с *ex vitro*
(хүлэмж)-нд шилжүүлсэн нь
О.Хонгорзул¹, Ю.Оюунбилэг¹
¹ШУА, Биологийн хүрээлэн, Ургамлын эсийн өсгөврийн лаборатори
centaurea26@gmail.com
- Адууны хачгийн халуун өвчнийг бабедазолоор эмчлэн, урьдчилан
сэргийлсэн дүн
П. Мягмарсүрэн¹, Б. Батцэцэг¹, Б. Баттөр^{1,2}
Мал эмнэлгийн хүрээлэн¹
ХААИС-ийн МДМЗС²
mgn_p@yahoo.com
- Шавжны өвчин үүсгэгч болон эндосимбионтын төрөл зүйлийн
тархалтын судалгаа
Б.Пагмадулам¹, Janet Jennifer Luangsa-Ard²,
Suchada Mongkolsamrit¹,
Д.Цэрэндулам²
Тайландын Биотехнологи,
генетик инженерчлэлийн хүрээлэн, Микологийн лаборатори¹
ШУА-ийн Биологийн хүрээлэн,
Микробын нийлэгжлийн лаборатори²
И-мэйл: pagm_b@yahoo.com
- Chenopodium album* L-ийн гербицидэд тэсвэрлэсэн дүнгээс
Т.Азаяа¹, М.Отгонсүрэн¹, Г.Цэрэнханд²
Ургамал Хамгаалал Эрдэм Шинжилгээний Хүрээлэн¹
ШУА, Ботаникийн Хүрээлэн²
И-мэйл: t.azaa87@yahoo.com
- “Усалгаатай нөхцөлд нэг наст райграссын хэнзлэлт, ногоон массын
ургацанд тарих хугацаа, үрийн нормын нөлөө”
**Т.Хишигбуян / ЭШТуА/
Дархан-уул аймаг УГТЭШХ
e-mail: bankuhish@yahoo.com**

- Газар зүйн ялгаа бүхий тарваган Хайласны (*Ulmus pumila* L.) давсжилт тэсвэрлэх чадвар

Ц. Энхчимэг¹, Н. Батхүү²

¹ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн
²МУИС, ББС-ийн Ой судлалын тэнхим
enkhii_smile@yahoo.com

- Пивоны үйлдвэрийн хаягдал дрожжийг ашиглан дрожжийн автолизат хийсэн туршилтын дүн

Ц.Уянга*, Д.Цэрэндулам** Ч.Мягмар***

*УХЭШХүрээлэн, **ШУА-ийн биологийн хүрээлэн
Uyanga0625@yahoo.com

- Хахуун голын хорын туршилтын амьтанд үзүүлэх эмгэг бие бүтцийн судалгаа

Ө.Жаргалсайхан*, Я.Ганболд*, С.Жавзан**

*Мал эмнэлгийн хүрээлэн
 ** ШУАкадемийн Хими, хими технологийн хүрээлэн
 e-mail: jargal_eq@yahoo.com

- Тариалангийн төв бүсэд тэжээлийн арвайн сортуудын ургац, технологийн чанарыг судалсан дүн

Я. Мөнхтуяа¹, Магистр

Ж.Намжилсүрэн², Ph.Доктор
 УГТЭШХ

munkhsun@yahoo.com,

- Transgenic rice expressing human antimicrobial Peptide shows enhanced resistance to bacterial blight

Davaasuren Yondonjamts¹, Maral Gandal², Jadamba Vandan³ and Bayarbat Ishvaanjil*

^{1, 3, *} Department of Chemistry,

School of Natural Science, Mongolian State University of Agriculture

² Main Laboratory of Food Analysis,

Food Resource and Manufacturing SAMO Institute

¹Author: D.Y E-mail: daavkaa2001@yahoo.com

*Corresponding author: B.I, E-mail: bayarbat.i@gmail.com

ГОВИЙН АЙМГУУДАД ТОХИОЛДДОГ ОНОШ НЬ ТОДОРХОЙГҮЙ АДУУНЫ ӨВЧНИЙ СУДАЛГААНД

Б.Энхтайван, Г.Жавхлан, Б.Баттөр, Б.Батцэцэг

Мал эмнэлгийн хүрээлэн, Молекул генетикийн лаборатори

bata07@gmail.com

ХУРААНГУЙ

Адууны анаплазмоз нь цусны цагаан эсэд шимэгчилдэг *Anaplasma phagocytophilum* зүйлээр үүсгэгддэг, хачгаар дамжин халдварладаг. Уг өвчний үүсгэгч *Anaplasma phagocytophilum* зүйл нь хонь ямаа, үхэр, нохой, муур болон зэрлэг хивээгч амьтдад, хүнд өвчин үүсгэдэг. Монгол оронд адууны анаплазмоз өвчний талаар судалгаа огт хийгдээгүй байсан бөгөөд бидний хийсэн судалгаа анхных юм. Судалгаандаа нийт 72 адууны цусны дээжээс ДНХ-г ялган, *A. phagocytophilum* зүйлийн өвөрмөц groEL генийн хэсгийг ПГУ-аар олшруулан илрүүлэхэд шинжилсэн дээжийн 10 нь буюу (13,8%) дээж эерэг дүн үзүүлсэн байсан.

ТҮЛХҮҮР ҮГ: Адууны анаплазмоз, *Anaplasma phagocytophilum*, ПГУ

STUDY OF HORSE DISEASE WITH UNCLEAR REASON IN THE GOBI AREA

Enkhtaivan.B, Javkhlan.G, Battur.B, Battsetseg.B

bata07@gmail.com

*Anaplasmosis is tick-transmitted disease of human, horse, sheep, goat, cat, dog, and some wild ruminants caused by infection with the white cell parasite *Anaplasma phagocytophilum*. In this study a total of 72 blood sample from horses in Dundgovi province were examined by microscopy and PCR. The both analysis detected *A.phagocytophilum* in 10 (7,2%) samples. The *A.phagocytophilum* detected by microscopy and PCR in horse of Mongolia firstly in this study.*

*Key word: Equine anaplasmosis, *Anaplasma phagocytophilum*, microscopy, PCR*

Үхрийн цусан халдварыг оношлох шууд иммуно флуоресцент урвалын флуоресцент ийлдэс\IgG\ бэлтгэн сорьсон дүн

Б.Энхтуул¹, Ц.Лундаа¹,
Б.Нарангэрэл¹, Д.Ганболд²,
Б.Мөнгөн-Очир², Ж.Эрдэнэбаатар¹

¹Мал эмнэлгийн хүрээлэн, Халдварт өвчин, дархлаа судлалын лаборатори,

²Эмгэг судлалын лаборатори
Зайсан Улаанбаатар, Монгол улс,

Товчлол: Цусан халдвар нь Грам сөрөг жижиг савханцар *Pasteurella multocida* төрлийн нянгаар үүсгэгддэг, дэлхийн олон улс оронд өргөн тархсан цочмог халдварт өвчин бөгөөд өртөмтгий амьтан нь үхэр, хонь юм. Манай орны хангай, тал хээрийн бүсэд зонхилон гарч улс орны эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг халдварт өвчин юм.

Цусан халдварыг эмнэл зүйн шинж тэмдэг, нян судлалын аргаар оношлодог. Нян судлалын аргаар оношлоход харьцангуй их цаг хугацаа зарцуулдаг, лабораторийн нөхцөлд, нян судлалаар мэргэшсэн хүн хийх шаардлагатай зэрэг сул талтай учир өвчнийг түргэн оношлох шинэ аргыг боловсруулах шаардлага тавигдаж байна.

Үхэр, хонины цусан халдварыг оношлох дархан туяарах өвөрмөц ийлдсийг *P.multocida* №18 В омгоор туулайд хэт дархлаажуулалт хийн, хэт дархлаат ийлдэс гарган авч, түүнээсээ иммуноглобулин G-г тунадасжуулан, цэвэршүүлж флуорес-цейн изотиоционат (ФИТЦ)-тай холбон гаргаж авсан. Уг оношлуур нь цочмог хэлбэрээр өвчилж, үхсэн үхэр, хонины эмгэгт материал болон түүнээс өсгөвөрлөсөн өсгөвөрөөс түрхэц бэлтгэн уг оношлуураар /дархан туяарах ийлдсээр/ үйлчлүүлэн харахад мэдрэг, өвөрмөц чанартай болох нь тодорхойлогдов.

Түлхүүр үг: Үхрийн цусан халдвар, *B.multocida*, дархлаат глобулин, флуоресцент ийлдэс.

Abstract

Haemorrhagic septicaemia (HS) is acute infectious disease, distributed broadly in the world, caused by gram negative bacillus, *Pasteurella multocida*. Its occurrence can have devastating consequences for the economy of a country and cattle and sheep are more susceptible for this disease. It is occurred in mountainous and steppe area of Mongolia, especially among yak population.

Popular diagnostic method of haemorrhagic septicemia (HS) is specific clinical signs and bacteriological analysis. However, it has some disadvantages, which spend a lot of time, only specialist can do in the bacteriology laboratory. Therefore, it is requiring to develop new method to rapid diagnose the disease.

Hyper immune sera from rabbit, immunized with strain *P.multocida* №18 В, were used for purification of specific IgG and conjugated with FITC. This conjugate was sensitive and specific for detection of *P.multocida* in the direct slide smears of *P.multocida* culture and pathological materials from naturally infected animals.

ДАВСАНД ТЭСВЭРИЙГ КОДЛОГЧ *WRKY1* ГЕНИЙГ ЯЛГАЖ АВАХ БА ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ

Болдын Одгэрэл¹, Dae Yeon Kim², Woong Bae Jeon², Энхчимэг Ванжилдорж³, Yong Weon Seo*

1-odgerel1017@yahoo.com, 976-9913-7748, Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Зайсан-210153, Улаанбаатар, Монгол улс

2-Корей их сургууль, Биотехнологийн коллеж, Сөүл, 136-713, БНСУ

3-ХААИС, Биологийн нөөцийн менежментийн сургууль, Биотехнологи үржүүлгийн тэнхим, Зайсан-17024, Улаанбаатар, Монгол улс

ХУРААНГУЙ

Энэ судалгаанд бид давсанд тэсвэрийг кодлогч *WRKY1* генийн тухай мэдээлэлийг “Тутрагыг төрөл бүрийн фитогормоноор үйлчлэхэд *WRKY* бүл генийн дэлгэрэнгүй транскрипцийн илрэл” (Rengasamy нарын) бүтээлээс давсанд тэсвэртэй шинж чанарыг кодлогч тутрага (*Oryza sativa* L.)-ийн геномоос ялган авч дарааллыг нь тогтоосон 26 генийн мэдээллийг тус тус ашиглав. Тутрага (*Oryza sativa* L.)-ийн *WRKY1* генийн мэдээлэлийг (http://rice.plantbiology.msu.edu/analyses_search_locus.shtml) сайтаас мөн *Brachypodium*-ийн *WRKY1* генийн мэдээллийг (<http://www.phytozome.net/brachy.ph>.) сайтнаас авсан. Үүний дараа дээрх генүүдийн давхцаж байгаа дарааллын ижил хэсгийг CLUSTALW-ээр тодорхойлж *Brachypodium*-ийн *WRKY1* генийн филогенетикийн зураглалын хийв. Бидний урьдчилан таамаглаж байсан генүүдийн кДНХ-ийн дараалал 85% ижил байна гэсэн нотолгоог [LOC_Os03g53050|13103.t04632|unspliced-genomic](#) мэдээллээс олж авсан ба үүн дээр үндэслэн бид *WRKY1* ген нь абиотик стресс түүн дотроос давсанд тэсвэрлэх шинж чанарыг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

WRKY транскрипцийн хүчин зүйл, давсанд тэсвэр, *Brachypodium distachyon*, тутрага (*Oryza sativa* L.)

WRKY1- Salt Stress Tolerant Gene Isolation and Transformation

Odgerel Bold¹, Dae Yeon Kim², Woong Bae Jeon², Enkhchimeg Vanjildorj³, Yong Weon Seo^{2*}

Plant originated product assessment laboratory, Plant Protection Research Institute, Zaisan-210153, Mongolia¹

College of Life Sciences and Biotechnology, Korea University, Seoul, 136-713, Korea²

College of Biological resource and management, Mongolian State University of Agriculture, Zaisan-17024, Mongolia³

odgerel1017@yahoo.com

Abstract

WRKY proteins are newly identified transcription factors involved in many plant processes including plant responses to biotic and abiotic stresses. To date, genes encoding WRKY proteins have been identified only from plants. Comprehensive search for WRKY genes in non-plant organisms and phylogenetic analysis would provide invaluable information about the origin and expansion of the WRKY family. In this research, we use information salt up regulated WRKY genes “A Comprehensive Transcriptional Profiling of the WRKY Gene Family in Rice under Various and Phytohormone Treatments” Rengasamy Ramamoorthy et al., 2008 on the internet, available sequence data for 26 salt up-regulated WRKY genes in the rice genome. Gene predictions were performed with the Rice Genome Automated Annotation System (http://rice.plantbiology.msu.edu/analyses_search_locus.shtml). Brachypodium WRKY genes were obtained by searching the Brachypodium genome annotation <http://www.phytozome.net/brachy.php>. Alignment of the cDNA sequence and peptide sequences of the WRKY was performed using CLUSTALW and then made by brachypodium salt up-regulated WRKY1 genes phylogenetic tree. The predicted genes were compared with their cDNAs obtained from internet result was 85% in rice LOC_Os03g53050|13103.t04632|unspliced-genomic WRKY transcription factor, putative, expressed. On the basis of these results, we believe that WRKY1 gene play role of abiotic stresses and such as salt tolerances.

Key words: WRKY transcription factor, Salt tolerance, *Brachypodium distachyon*,

ПИВОНЫ ДИАЦЕТИЛИЙН ХЭМЖЭЭНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

Б.Шинэзаяа¹, С.Дэлгэрмаа (Ph.D)²

¹ ШУТИС, ХИБС, Хүнсний микробиологи, магистрант

² ШУТИС, ХИБС, Биотехнологийн баг, дэд профессор
e-mail:zaya_1619@yahoo.com 99986612

Товчлол

Энэхүү судалгааны ажлаар пивоны чанарын гол үзүүлэлт болох диацетилийн хэмжээг 5 төрлийн пиво (Боргио, Tiger, Чингис, Gem draft, Монгол)-нд орчин үеийн шинжилгээний дэвшилтэт арга болох хийн хроматографиар тодорхойлон, харьцуулж дүгнэлт өгсөн. Мөн диацетилийн хэмжээ өсөх болсон шалтгааныг олж илрүүлсэн болно.

Түлхүүр үг: Хийн хроматографи, бохирдуулагч бичил биетэн

SUMMARY (IN ENGLISH):

“Result of study to defining the influence factor of diacetyl content in beer”

B.Shinezaya, S.Delgermaa (Ph.D)²

¹ Mongolian University of Science and Technology, *Food microbiology, master*

² Mongolian University of Science and Technology, *Biotechnology, adjunct professor*
e-mail:zaya_1619@yahoo.com 99986612

Abstract

By this study, we analyzed to define the diacetyl content that is main indication of beer quality. We used modern high-tech measures of gas chromatography on comparing 5 types of beers (Боргио, Tiger, Чингис, Gem draft, Монгол) and made the conclusion. Moreover, we discovered the reason that diacetyl content increases.

ХҮНИЙ БИЕД АГААРЫН ТЕМПЕРАТУРЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ СУДАЛСАН ДҮНГЭЭС

(Улаанбаатар хотын жишээн дээр)

Б.Шүрэнцэцэг¹, Ш.Оюунтуяа²

Ì î í ã ë ö ã ñ, ÕÀÀÈ Ñ, Ý ê î ë î ã è, ò ã õ î î ë î ã è ò ° ã ø è è é í ñ ó ð ã ó ó è ü

¹-[shuree 7111@yahoo.com](mailto:shuree7111@yahoo.com)

²-oyuntuya-sh@msua.edu.mn

Хураангуй

Агаарын температурын хоногийн доторх өөрчлөлтийн хэмжээ жил, улирлаар харилцан адилгүй байх ба хүний бие, эрүүл мэндэд тэр хэмжээгээр эерэг болон сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Цаг агаар-уур амьсгалын нөхцлийг хүний биед нөлөөлөх байдлаар нь үнэлэхдээ агаар мандлын буюу цаг уурын, сансрын буюу цацрагийн, дэлхийн буюу эх газрын гэж хувааж үздэг.

Энэхүү өгүүлэлд хот суурин газарт хүйтний улирлын хоног хоорондын агаарын температур хүний биед хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлохыг зорилоо.

Үүний тулд сүүлийн жилүүдээс хамгийн хүйтэн байсан 2009-2010 онд шилжих хүйтний улирлын агаарын температурын хоногийн өөрчлөлтийг цаг уурын Улаанбаатар станцын мэдээнд үндэслэн тооцоолж хүний биед нөлөөлөх байдлаар нь ангиллаа. Хүйтний улирал гэдэгт XI-III сарыг хамруулж үздэг билээ. Хүйтний улирлын 53 хоногт нь хоногийн дундаж агаарын температурын өөрчлөлт 2.5⁰C-аас бага буюу хүний биед тохиромжтой, 52 хоногт нь 2.6-4.5⁰C буюу харьцангуй тохиромжтой, 138 хоногт нь 4.6⁰C-аас их буюу тохиромжгүй байна. Хүний биед тохиромжгүй байх тохиолдол нь ихэвчлэн хавар, намрын шилжилтийн үед ажиглагдлаа.

Түлхүүр үг

Хүйтний улирал, био-уур амьсгал, өөрчлөлт, тохиромжтой, харьцангуй тохиромжтой, тохиромжгүй, хоногийн явц, үнэлгээ

RESULTS OF STUDY ON TEMPERATURE EFFECTS IN HUMAN BODY

B.Shurentsesteg¹, Sh.Oyuntuya²

School of Ecology and Technology Development, MSUA

[1-shuree_7111@yahoo.com](mailto:shuree_7111@yahoo.com)

[2-oyuntuya-sh@msua.edu.mn](mailto:oyuntuya-sh@msua.edu.mn)

Summary

Our study aimed to investigate the effect of air temperature during cold seasons on human body in urban areas. To evaluate effects of climatic conditions on human body they can be divided into atmospheric or climatic, space or radiation and earth or main land. Changes of daily air temperatures differ with years and seasons, and they exert such extent of effects on human body and health.

In this study daily fluctuations of air temperatures during cold season in 2009-2010, which are coldest in the last years, were estimated on the basis of data from Ulaanbaatar station and they were classified according to effects on human body. Cold season is months from November through March. Daily average air temperature fluctuation in 53 days of cold season was less than 2.5⁰C or suitable to human body function, while it was 2.6-4.5⁰C in 52 days and more than 4.6⁰C in 138 days or unsuitable for human body. Periods unsuitable for human body are mostly observed during transition in spring or autumn seasons.

ГОВИЙН БҮСИЙН ЛАВАР НАВЧИТ УЛИАСЫГ (*POPULUS LAURIFOLIA* L.) ЭРЛИЙЗЖҮҮЛСЭН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

Э.Батдорж*, Б.Цэнгэл**, Х.Билгүүн***

*ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн

**МУИС Биологи-Биотехнологийн сургууль

***Tree Global Mongolia ХХК

E_hoomboo@yahoo.com

Хураангуй

Энэхүү судалгааны ажлаар бид 2012 оны хавар, Монгол Алтайн нурууны төгсгөл хэсэг болох Өмнөговь аймгийн нутаг дахь Зүүнсайхан ууланд ургаж буй лавар навчит улиасны популяци дээр хэмжилт тооллого явуулж, цэцэгт мөчир бэлтгэн анхилуун улиастай эвцэлдүүлэх туршилт явуулав. Нийт 123 мод тоологдсоноос 90 мод буюу 73 хувь нь өсвөр насны мод байв. Цэцэгт мөчир бэлтгэх боломжтой бүх модноос мөчир бэлтгэхэд бүгд эр мод байсан бөгөөд эвцэлдүүлгийг усанд суулгасан эм улиасны мөчир дээр Пятницкийн тодорхойлон бичсэн аргагүйн дагуу гүйцэтгэв. Нийт 350 тарьц ургуулснаас 250 ширхэгийг бортогонд, 100 ширхэгийг ил талбайд ургуулав. Тарьцны газрын дээд хэсгийн шугаман өсөлтийг хэмжихэд дунджаар 20.62 см өндөртэй, үндэсний хүзүүний бүдүүн 0.39 см байв. 2012 оны 10 сарын 4 гэхэд өсөлт нь зогсож тайван байдалд орсон.

Түлхүүр үг: селекти, тоос, эвцэлдүүлэг, тарьц

SUMMARY: THE RESULTS OF GETTING INTERSPECIFIC HYBRID SEEDLINGS OF *POPULUS LAURIFOLIA* L. FROM GOBI REGION.

E.Batdorj (Institute of Geoecology), B.Tsengel, (Department of Forest Sciences, National University of Mongolia) Kh.Bilguun (Tree Global Mongolia LLC)

In recent years, laurel leaf poplar became one of the most widely used tree species in Mongolia for urban landscaping and windbreak forest. The objective of this study was to investigate and evaluate possible breeding, propagating values of isolated population of laurel leaf poplars in Zuunsaikhan mountain of Mongolian Altai range. Total 123 individual trees counted, of which 90 trees, or 73 percent fell into young trees that have 8-10 cm diameter by breast height and average 2 meters height.

Prepared branches with flower bearing buds from laurel leaf poplars and placed them in water culture. After pollens are collected, branches of female *Populus suaveolens* Fisch. were set in water culture. Total 350 hybrid seedlings grown, of which 250 in containers and 100 in seedbed, both in greenhouses. Average height of seedlings was 20.62 cm and root collar diameter was 0.39 cm by the end of growing season.

LEONTICEAE ТРИБИЙН (BERBERIDACEAE JUSS.) ҮРИЙН ХЭЛБЭРЗҮЙ, ҮРИЙН БҮРХҮҮЛИЙН ДОТООД БҮТЭЦ

Г. Биндэръяа

Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургуулийн Байгалийн ухааны сургууль,

Биологийн тэнхим e-mail: binderiya_gonchigdorj@yahoo.com

Товчлол

Судлагдсан Leonticeae трибийн зүйлүүдийн үр ихэвчлэн бөөрөнхийдүү, бөмбөлөг хэлбэртэй, хар хүрэн, хүрэн, цайвар шаргал өнгөтэй. Үрийн бүрхүүл ялгараагүй хэв шинжийн (undifferentiated seed coat type) дотоод бүтэцтэй. Гадаад эпидермисийн эсүүд ихэвчлэн ширхэглэг, нимгэн давхрааг үүсгэнэ. Түүний дотор талд нимгэн бүрхүүл бүхий хэд хэдэн эгнээ эсүүд байрлах ба тэдгээрийг паренхим эдийн давхраа гэнэ. Боловсорч гүйцсэн үрэнд нэг эгнээ эсээс тогтсон нимгэн, ширхэглэг давхраа нь дотоод эпидермис болно.

Үрийн гадаргуу олон өнцөгт-товгор торлог, давхар эмжээр бүхий гурвалжиндуу, дөрвөлжиндүү хонхор-торлог, гөлгөр-торлог, барзгар-бөмбөлөг хээтэй.

Түлхүүр үг: Caulophyllum, Gymnospermium, Leontice, ялгараагүй хэв шинж, үрийн гадаргуу

SEED MORPHOLOGY AND SEED COAT ANATOMY OF TRIBE LEONTICEAE (BERBERIDACEAE JUSS).

Binderiya Gonchigdorj

Department of Biology, Mongolian State University of Agriculture, Ulaanbaatar
210153, Mongolia,

e-mail: binderiya_gonchigdorj@yahoo.com

Summary

Caulophyllum, *Gymnospermium* and *Leontice* belong to the tribe Leonticeae. Five species of Leonticeae belonging to three genera were investigated in this study. This study presents the features of seed morphology and seed coat anatomy in genus level of the tribe. The seed size, shape, and color are very diverse.

Tribe Leonticeae have undifferentiated seed coat type. The outermost or epidermal layer of outer integuments is mostly thin-walled, with large nucleus parenchymatous cells forming spongy tissue in *Caulophyllum*, whereas in *Gymnospermium* and *Leontice* have fibrous and thin layers. Below the epidermal layer, in the middle of outer integument, is a subepidermal layer that more cell layers and typically parenchymatous in these genera. The innermost layer of inner integuments formed of parenchyma cells compressed at maturity, is referred to as the thin-

layers in *Gymnospermum* and *Leontice*. The seed surface is colliculate, convex-reticulate and globoid-embossed.

НҮЦГЭН ОРТУУЗЫН ХОРДЛОГЫГ ОНОШЛОЖ, ХЭТ ДАРХЛААТ ИЙЛДЭС ТУРШСАН ДҮН

Д.Баярмөнх¹, Г.Оюунцэцэг¹, А. Шимада²,
В.Батбаатар¹, Ж.Эрдэнэбаатар¹
¹Мал Эмнэлгийн Хүрээлэн,
²Тоторрогийн Их Сургууль,
Bayarmunkhd@gmail.com

Товчлол

Хорт ургамлын хор хөнөөлөөс мал сүргийг урьдчилан сэргийлэх найдвартай арга боловсруулахын тулд тухайн газар, нутаг, аймаг, сумын хор хөнөөлт ургамлыг олж илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хорио цээрийн хугацаа тогтоох, эмчлэх, сэргийлэх аргыг мал эмнэлгийн анхан шатны нэгжүүд, малчидад сурталчлах, эзэмшүүлэхталаар олон хэлбэрийн ажлуудыг хослон зохиох шаардлагатай байдаг. Сүүлийн хэдэн жил Нүцгэн ортууз (*O. Glabra*)-ын хордлогын улмаас Завхан голын ай сав дагуу нутаглаж буй Завхан, Говь-Алтай аймгийн 40 гаруй өрхийн мал ортууз идэж, 10000 гаруй толгой мал 2007-2011 онд хордлогын шинж тэмдгээр өвчилж үхсэн байдаг. Бид дээрх хорт ургамлын хордлогыг оношлох эмчлэн сэргийлэх аргыг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Судалгааны ажлын үр дүнд:

-Нүцгэн ортуузын хордлого нь нийлбэр алкалоидоор нөхцөлдөн үүсч, малын дээд мэдрэлийн тогтолцоонд нөлөөлж, бага тархины Пуркинъегийн эсийн сөнөрөл, тархины глийн эсүүд (астроцит, микрогли) олшрох, Пуркинъегийн эсээс гаралтай аксон болон миелинүүд уусч алга болох зэрэг эмгэг өөрчлөлтүүд үзүүлэх ба энэ нь малын бөгсөн биеийн саажилт, шилэн хүзүүний таталтаар илэрч улмаар үхэлд хүргэж байгааг гистологи, гистохими, иммуногистохимийн аргуудаар баталгаажуулав.

-Нүцгэн ортууз (*Oxytropis Glabra*) –ын биологийн идэвхит бодис нийлбэр алкалоидыг ELISA-ын эсрэгтөрөгч болгон хэрэглэж, хордлогыг оношлох боломжтой байна.

-Нүцгэн ортуузын хордлогын үед өвөрмөц идэвхитэй дархлаат ийлдсийг эмчилгээнд хэрэглэх боломжтойг тогтоов. Цаашид энэхүү хэт дархлаат ийлдсийг хордлоготой бүс нутагт нийлүүлж жил бүр хордлогын улмаас гарах хохиролыг багасгах, мал эмнэлгийн ажил үйлчилгээнд нэвтрүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: *Oxytropis Glabra*, indirect ELISA, Иммуногистохими, Пуркинъегийн эс, Хэт дархлаат ийлдэс, LD₅₀

Summary

The study aimed to study pasture plant species compositions, distributions and biological resources along the basin of Zavkhan river, clarify the species of toxic plants, develop measures and recommendations for diagnosis and prevention of the intoxications, and implement them. In order achieve above goal, the following objectives were put forward:

-To perform chemical and pharmacological studies for detection of biologically active matters of toxic plants

-To trace possibilities of production of hyperimmune serum and diagnosis of plant poisoning with ELISA.

Median lethal dose of *Oxytropis glabra* is 0.49 g/kg and concentration of swainsonine contained in sum alkaloid causing intoxication in animals is 61.8 mg/g. Biologically active matter or sum alkaloids of *Oxytropis glabra*, which intoxicate animals, have antigenicity (immunogenicity).

It is possible to use biologically active matter or sum alkaloids of *Oxytropis glabra* as an antigen of ELISA test and diagnose plant poisoning by using this test. It is necessary to improve it in the future.

It has been important to use immune serum for prevention of poisoning with *Oxytropis glabra* and investigate continuously its therapeutic effect.

“МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УСНЫ ИДЭВХИЙН СУДАЛГАА ”

Д.Болорцэцэг¹, С. Лхагвасүрэн,¹ Ч.Нямцэнгэл², Ү.Нямбат³

¹ ХААИС, Мал эмнэлгийн хүрээлэн

²Экологи Технологи Хөгжлийн Сургууль

³Эдийн засаг бизнесийн сургууль

Емайл: tsasanbolor_88@yahoo.com

Хураангуй:

Дэлхийн зах зээлд махны эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа өнөөгийн үед монголд махны үйлдвэрлэл, экспортыг дэмжиж шинэ технологи, эрүүл ахуйн сайн дадалыг нутагшуулах шаардлагатай байна.

Усны идэвх (A_w) нь бүтээгдэхүүний химийн ба ферментийн өөрчлөлт буюу өнгө, үнэр, амт, нянгийн өсөлт, хадгалагдах хугацааны хамаарлыг хянаж болох, сааталын технологи ба завсарын чийгшилтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шийдвэрлэх ач холбогдолтой интеграл үзүүлэлт юм. (Г.Хайнц Мах боловсруулах технологи)

Энэ судалгаагаар зарим монгол малын махны усны идэвхи (A_w)–ыг тогтоож, рН, чийг, нянгийн бохирдолттой нь харьцуулан судлав. Адуу, үхрийн махны A_w 0.86, хонины махных 0.88 байна. Хүйтний боловсруулалт хийсэн махны A_w - ийн дундаж 0.97; халууны боловсруулалт хийсэн махных 0.88; химийн боловсруулалт хийсэн буюу нитрит нэмсэн махны A_w –ын дундаж 0.81, байна. Үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал, харилцан шүтэлцээ байгаа эсэхийг корреляцын хос шугаман

коэффициентыг ашиглан шинжлэхэд түүхий махны a_w ба pH-ын хооронд тодорхой хамааралгүй, харин давс нитрит нэмсэн бүтээгдэхүүнд хамааралтай байна. Махны чийг ба нянгийн бохирдолтын хэмжээ a_w -тэй шууд хамааралтай байна. Хонины махны a_w боловсруулалтын аль ч төрөлд тогтворгүй байна.

Түлхүүр үг: *Малын төрөл; мах; халуун, хүйтэн, химийн боловсруулалт; a_w , бусад үзүүлэлт, тэдгээрийн хамаарал*

SURVEILLANCE OF WATER ACTIVITY OF MEAT AND MEAT PRODUCTS

Bolortsetseg.D¹, Lkhagvasuren.S¹, Nyamtsengel.Ch², Nyambat.U³

¹ **Institute of Veterinary Medicine, MSUA**

² **School of Ecology and Technology**

³ **School of Business and Economy**

Эмэйл: tsasanbolor_88@yahoo.com

Summary

It has been necessary to adopt new technologies and good hygienic practice to support meat production in and export from Mongolia during current situation of increasing the demands of meat in worldwide markets.

Water activity is an integral parameter capable of controlling the chemical and enzymatic changes or interrelationships between color, smell, taste, microbial growth and storage period, and crucially important for hurdle technology and manufacturing of products with intermediate moistures. In our condition, theoretical and practical importance of this parameter has not been defined.

In the present study, water activity of native Mongolian livestock meat was determined and investigated in comparison with pH, moisture and microbial contamination. Water activity of horse meat and beef is 0.86., while mutton water activity is 0.88 Average water activity of cold treated, thermally processed meat, chemically processed or nitrate added, and salted meat is 0.97, 0.81 ,0.88, and respectively. Analysis of relationships and intercorrelations between the parameter values by using double linear coefficient of correlation reveals raw meat water activity and pH had no definite relationships, but there was a relationship for those products added salt and nitrite. Meat moisture and microbial contamination are directly proportional to water activity. Water activity of mutton is unstable for all types of processing.

Keywords: animal type, meat, heat, cold, chemical processing, water activity, parameters, relationships

БАЙГАЛЬ ГҮҮНХӨХИЙГ *IN VITRO* НӨХЦӨЛД ӨСГӨВӨРЛӨХ БОЛОМЖ

Д.Бямбасүх¹

¹ Монгол улс, ШУА, Ботаникийн хүрээлэн, Ургамлын бичил үржүүлгийн лаборатори

byambasukh@yahoo.com, 99789071

Хураангуй

Scutellaria baicalensis Georgi(цаашид Байгаль гүүнхөх гэх)-ийн газрын дээд бие, үндсийг уламжлалт болон орчин үеийн анагаах ухаанд янз бүрийн өвчнийг анагаахаар өргөнөөр хэрэглэдэг. Байгаль гүүнхөхийн үрийг ариутгаад үндсэн МС тэжээлийн орчинд тавьж соёолуулсан. 28 хоногийн дараа цухуйцаас нахиа бүхий ишний хэсэг/үений эксплант/-ээр 0,5-1 см урттайгаар тайран авч бензиламинопури/БАП/ 1мг/л, кинетин/КИН/ 1мг/л концентрациар агуулсан бүтэн МС орчин, мөн КИН 1мг/л концентрациар агуулсан ½ МС тэжээлт орчнуудад суулгасан. 21 хоногийн дараа нахианы тоог тоолоход БАП 1мг/л мөн КИН 1мг/л концентрациар агуулсан бүтэн МС тэжээлт орчны хувилбар хамгийн сайн үр дүнг үзүүлсэн. Найлзууруудаа ямар нэг өсөлтийн бодисгүй ½ МС орчинд суулгахад 7-10 хоногт үндэс үүсч, 21-28 хоногт 95% нь үндэслэж байсан.

Мөн цухуйцаас ишний хэсгээр нь эксплант авч КИН 2мг/л ба ИЦХ 2мг/л концентрациар бүтэн МС орчинд байрлуулахад шар өнгөтэй каллус үүсч байсан.

Түлхүүр үг: анагаах ухаан, нахианы тоо, каллус, МС орчин, кинетин, бензиламинопури

IN VITRO PROPAGATION OF SCUTELLARIA BAICALENSIS GEORGI.

D.Byambasukh

Plant micropropagation laboratory, Department of plant physiology and micropropagation, Institute of Botany, MAS

E-mail: byambasukh@yahoo.com

Radix of *Scutellaria baicalensis* Georgi. is widely used for traditional and contemporary medicine. Seeds of *Scutellaria baicalensis* Georgi. were surface sterilized and germinated on the MS medium. 28 days later, seedlings cut to 0.5-1 cm length pieces by nodal segment and cultured on the ½ MS medium with kinetin 1mg/l and MS medium with benzylaminopurine and kinetin 1mg/l, respectively. 21 days later, counted buds of shoots. MS medium with 1mg/l benzylaminopurine and 1mg/l kinetin were best version for bud propagation. All shoots were rooted on the ½ MS medium without any growth regulators. 28 days later, 95 percent of all cultured shoots were induced root.

Also, excised explants from stem segment of seedling and cultured on the MS medium with 2 mg/l kinetin and 2 mg/l indole acetic acid. Whereas, formed yellow colored callus.

УСАЛГААТАЙ НӨХЦӨЛД АРВАЙН СОРТУУДЫН ХУУРАЙ БИОМАССЫН ХУРИМТЛАЛД БОРДООНЫ НӨЛӨӨ

Д.Хишигжаргал/ магистр/¹

Д.Туул /Ph.D/

ДАРХАН-УУЛ АЙМАГ УГТЭШХ

[e-mailjargald_0110@yahoo.com](mailto:jargald_0110@yahoo.com)

Оршил

Ургацын бүтээгдэхүүнт чанарыг илэрхийлэгч хүчин зүйлийн нэг нь газрын гадаргын хуурай масс бөгөөд түүний хэмжээг нэмэгдүүлэх явдал нь газар тариаланд чухал ач холбогдолтой.

Арвай нь бусад үр тарианы таримлаас ялгагдах биологийн онцлог нь – газрын гадаргын дээрх нийт биомассын хагасаас илүү хувь нь үр боловсроход зарцуулагддаг.

Түлхүүр үг: Усалгаа, бордоо, хуурай биомасс, фотосинтез

ТӨВ АЙМГИЙН АДУУНЫ ХАЧГИЙН ХАЛУУН ӨВЧНИЙ ХӨДЛӨЛЗҮЙГ СУДАЛСАН НЬ: 2007-2010 ОН

Г.Жавхлан¹, Б.Батцэцэг¹

¹Мал Эмнэлгийн Хүрээлэнгийн Молекул Генетикийн Лаборатори,
Монгол улс, Улаанбаатар хот 210153, Зайсан

javkhlan.g@gmail.com

Адууны хачгийн халуун нь *Theileria equi* болон *Babesia caballi* зүйлийн эгэл биетнээр үүсгэгддэг, хачгаар дамжин халдварладаг, эдийн засгийн ихээхэн хохирол учруулдаг өвчин юм. Уг өвчин нь Монгол орны төвийн бүсэд өргөн тархсан байдаг.

2007-2010 оны хооронд Төв аймгаас цуглуулсан нийт 567 адууны цусны дээжид үүрэн полимеразийн гинжин урвал, рекомбинант эсрэгтөрөгчтэй фермент холбоот эсрэгбиеийн урвалаар адууны хачгийн халуун өвчний халдварыг илрүүлэх шинжилгээ хийв. Үүрэн ПГУ-аар нийт дээжийн 24.86%±10.17 нь *T.equi*, 14.98%±8.38 нь *B.caballi* илэрч, энэ хоёр үүсгэгчээр 5.96%±5.54 нь давхар халдвартай байна. Харин ФХЭБУ-аар *T. equi*-ийн халдвар 77.86%±8.33 and *B.caballi*-ийн халдвар 26.17%±7.01, давхар халдвар 23.43%±6.73 тус тус байлаа. 2007-2010 онуудад *T.equi*-ийн болон *B.caballi*-ийн халдвар жил бүр ялгаатай ($p<0.05$) байна.

Түлхүүр үг: *Theileria equi*, *Babesia caballi*, халдварлалт, one-way ANOVA

SURVEY STUDY OF EQUINE BABESIOSIS IN TUV PROVINCE DURING 2007-2010

Javkhlan G.¹, Battsetseg B.¹

¹Laboratory of Molecular Genetics, Institute of Veterinary Medicine,
Zaisan- 210153, Ulaanbaatar, Mongolia

javkhlan.g@gmail.com

Theileria equi and *Babesia caballi* is a tick-borne hemoprotozoan parasites which causes an economically important disease, equine babesiosis. The disease has been documented as widespread in horses of Central Mongolia.

Total 567 horse blood and serum samples were collected from Tuv province between 2007-2010, and diagnosed by nested polymerase chain reaction and enzyme linked immunosorbent assay with recombinant antigens. Infection of *T.equi* and *B.caballi* were 24.86%±10.17 and 14.98%±8.38, co-infection was 5.96%±5.54 by nested PCR. The seroprevalence was 77.86%±8.33 for *T. equi* and 26.17%±7.01 for *B.caballi*, co-infection was 23.43%±6.73 by ELISA, respectively. Significant difference was indicated for *T.equi* and *B.caballi* infections between 2007-2010 ($p<0.05$).

ДОРНОД АЙМГИЙН ХУР ТУНАДАСНЫ ӨӨРЧЛӨЛТ

Г. МЭНДСАЙХАН¹, Н.ЦЭРЭНСОДНОМ²

¹ ᠯ ᠠᠶᠢᠰᠢ ᠪᠦ ᠰᠤᠭᠡᠨ, ᠨᠠᠶᠤᠯᠠᠭᠡᠨ, ᠶᠡᠯᠡᠭᠡᠨᠡ, ᠳᠠᠳᠤᠬᠤᠶᠡᠨᠡᠭᠡᠨᠡ ᠰᠤᠭᠡᠨᠡᠭᠡᠨᠡ ᠨᠢᠨᠠᠳᠠᠰᠤᠨ

¹- mendee_cool@yahoo.com

²- tseke_baby88@yahoo.com

Хураангуй

Энэ судалгааны ажлаар зуны улиралд бусад бүс нутгаас хур тунадас ахиу ордог Дорнод аймгийн хур тунадасны өөрчлөлтийг хэд хэдэн үзүүлэлтээр судаллаа. Үүнд Дорнод аймгийн нийлбэр хур тунадасны статистик үзүүлэлтийг олон жилийн мэдээнд үндэслэн гаргалаа. Улмаар Дорнод аймгийн жилийн нийлбэр хур тунадасны өөрчлөлтийг тодорхойлж, эцэст нь жилийн нийлбэр хур тунадасны өөрчлөлтөд зүс болон аадар хур тунадасны нөлөөг тооцооллоо.

Эцэст нь эндээс Дорнод аймагт зуны хур тунадас жилийн хур тунадасны ихэнх хувийг эзэлж, олон жилийн өөрчлөлтөөс үзэхэд зуны хур тунадасны хэмжээ буурч, улмаар аадар борооны давтагдал ихсэж зүс тунадасных нь багассан үр дүн гарлаа.

Түлхүүр үг

Хур тунадасны өөрчлөлт, хур тунадасны статистик үзүүлэлтүүд, аадар болон зүс хур тунадасны өөрчлөлт.

THE RAINFALL CHANGE OF DORNOD AIMAG

G.MENDSAIKHAN¹, N.TSERENSODNOM²

¹School of Ecology and Technology Development, MSUA

¹- mendee_cool@yahoo.com

²- tseke_baby88@yahoo.com

Abstract

In this paper, we studied with several parameter precipitation change of dornod aimag of Mongolia to precipitate more than other region of Mongolia in summer. Here annual precipitation statistics of dornod aimag was created on the basis of many years data. Further we determined annual precipitation change for the aimag and computed an effect of gentle and continuous rain and rainfall in annual precipitation change.

To indicate at the conclusion, summer precipitation dominates the annual precipitation in the dornod aimag of Mongolia, and as we were showing many years change, we took results that summer precipitation reduced, rainfall frequency increased and gentle and continuous rain frequency decreased.

ЭРЧИМЖСЭН СҮҮНИЙ ҮХРИЙН ФЕРМЕРИЙН АЖ АХУЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

И.Ганчимэг¹, Ph.D Ч. Баасанжаргал¹, Ph.D А.Бааст²

Монгол улс, Монголын Үндэсний Их Сургууль,

Газар зохион байгуулалтын удирдлагын тэнхим

E mail: Ganaa_882888@yahoo.com

Хураангуй

Фермерийн аж ахуйн хөгжлийг судлаж өнөө үеийнхтэй харьцуулан газар төлөвлөлт хийх норм, стандарт боловсруулагдаагүй байгаа шалтгаануудыг судалж сүүний үхрийн фермерийн аж ахуйн газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд тулгамдаж буй хэд хэдэн бэрхшээлүүд байна.

Сүүний үхрийн “Ялгуусан” фермерийн аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэл нь тухайн үйлдвэрлэл явуулж байгаа газартайгаа тохирч байгаа бөгөөд тэжээлийн талбай хүрэлцээтэй боловч хадлан, бэлчээрийн талбай дутагдалтай. Энэ нь үхрийн тоог тогтмол хэмжээнд хязгаарлаж байж үйлдвэрлэлээ явуулах боломжтой төдийгүй өргөтгөх боломжгүйг харуулж байна. Иймээс фермерийн аж ахуйн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг урьдчилан тооцоолж үйлдвэрлэлийн чиглэл, хэмжээ, нөөц зэрэгт тулгуурласан газар олголтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: газрын зохист хэмжээ, үхрийн аж ахуй, төлөвлөлт, арга зам

ШАРГАЛ ЛИДРИЙН (*SOPHORA FLAVESCENS SOLAND*) IN VITRO ҮРЖҮҮЛЭГТ ӨСӨЛТИЙН БОДИСУУДЫН НӨЛӨӨ

М. Цолмон

ШУА, Ботаникийн хүрээлэн, Ургамлын бичил үржүүлгийн лаборатори

И-мэйл: Tsolmonbot@gmail.com,

Товчлол:

Энэ судалгаагаар Шаргал лидрийн *in vitro* өсгөөр эхлүүлэх, бичил ургамал гарган авч, улмаар *ex vitro* (хүлэмж)-д шилжүүлэх зорилгоор залуу нахиа бүхий ишний эксплантыг сонгон авч ауксин, цитокининий зарим төрлийн гормон хэрхэн нөлөөлөхийг туршиж үзсэн. Эхлээд *in vitro* нөхцөлд ариун, бичил биетний халдваргүй ургамалтай болохын тулд үрийг 4 дахин шингэрүүлсэн, 2 дахин шингэрүүлсэн, бүтэн Мурасиге-Скуге (MS) тэжээлийн орчинд соёололтын хувийг нь тодорхойлсон ба 2 дахин шингэрүүлсэн тэжээлийн орчин нь илүү тохиромжтой байв. Үрнээс соёолсон 14 хоногтой цухуйцаас нахиа бүхий ишний эксплантыг тайрч аван шинээр нахиа үүсгэхэд 3мг/л BAP, 0.2 мг/л NAA-тэй MS тэжээлийн орчин хяналттай харьцуулахад 5 дахин илүү нахиа үүсгэж байсан.

Бичил ургамлыг үндэслүүлэхэд MS тэжээлийн орчинд NAA (0.1мг/л; 0.3мг/л; 0.5мг/л), IAA(0.1мг/л; 0.3мг/л; 0.5мг/л) өөр өөр концентрацитай нэмж туршсан. Туршилтын үр дүнгээс үзэхэд 0.5 мг/л NAA, 0.5 мг/л IAA нэмсэн MS орчин үндэс үүсгэхэд эерэгээр нөлөөлж байсан ба цаашид нэмэлтээр 0.7; 0.9 мг/л туршиж үзэх шаардлагатай байна. 5-6 долоо хоногтой сайн үндэслэсэн бичил ургамлыг *ex vitro* (хүлэмж) шилжүүлж амьдрах чадварыг үнэлэх судалгааг эхлүүлээд байна.

Түлхүүр үг: *Sophora flavescens* Soland, *in vitro*, эксплант, *ex vitro*

Summary:

